

БАТЛАВ:



П.БАЯСГАЛАН /МОНГОЛЫН НҮДНИЙ ЭМЧ НАРЫН
НИЙГЭМЛЭГИЙН ТЭРГҮҮН/

НҮД СУДЛАЛЫН МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ТУСГАЙ ШАЛГУУР

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн багц цагийн богино хугацааны танхимын болон онлайн сургалтад хамрагдан жил бүр хамгийн багадаа 2 багц биелүүлсэн байх;
2. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх /гэрчилгээний хуулбар /-1 удаа;
3. Мэргэжлийн нүдний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байх - 1 удаа;
4. Эрдэм шинжилгээний хуралд аман болон ханын илтгэл, илтгэл хэлэлцүүлсэн байх- 1 удаа;
5. Мэргэшлийн чиглэлээр тухайн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон аймаг, сум, өрх, дүүргийн эмч нарт чиглэсэн сургалт зохион байгуулсан байх - 2 удаа;
6. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох телевизийн нэвтрүүлэг, онлайн контент, ном товхимол, гарын авлага бэлтгэн хүргэсэн байх - 1 удаа.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн багц цагийн богино хугацааны танхимын болон онлайн сургалтад хамрагдан жил бүр хамгийн багадаа 2 багц биелүүлсэн байх;
2. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх /гэрчилгээний хуулбар/ -1 удаа;
3. Ахлах зэрэг хамгаалсанаас хойших хугацаанд мэргэжлийн нүдний сэтгүүлд 2 удаа нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн байх.
4. Эрдэм шинжилгээний хуралд аман болон ханын илтгэл, илтгэл хэлэлцүүлсэн байх - 2 удаа;
5. Мэргэшлийн чиглэлээр тухайн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон аймаг, сум, өрх, дүүргийн эмч нарт чиглэсэн сургалт зохион байгуулсан байх - 3 удаа;
6. Мэргэшлийн чиглэлээр бусад нүдний мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байх - 2 удаа;

7. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох телевизийн нэвтрүүлэг, онлайн контент, ном товхимол, гарын авлага бэлтгэн хүргэсэн байх- 2 удаа.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн багц цагийн богино хугацааны танхимын болон онлайн сургалтад хамрагдан жил бүр хамгийн багадаа 2 багц биелүүлсэн байх;

2. Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх- 1 удаа;

3. Тэргүүлэх зэрэг хамгаалсанаас хойших хугацаанд мэргэжлийн нүдний сэтгүүлд 2 удаа нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн байх.

4. Эрдэм шинжилгээний хуралд аман болон ханын илтгэл, илтгэл хэлэлцүүлсэн байх - 3 удаа;

5. Мэргэшлийн чиглэлээр тухайн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон аймаг, сум, өрх, дүүргийн эмч нарт чиглэсэн сургалт зохион байгуулсан байх - 4 удаа;

6. Мэргэшлийн чиглэлээр бусад нүдний мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байх - 3 удаа;

7. Мэргэшлийн чиглэлээр ном, гарын авлага, удирдамж, стандарт боловсруулсан байх - 2 удаа;

8. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох телевизийн нэвтрүүлэг, онлайн контент, ном товхимол, гарын авлага бэлтгэн хүргэсэн байх - 4 удаа.

Жич: Доорх 2 заалт нь бүх зэргийн шалгуурт хамаарна.

- МНЭН-с зохион байгуулсан хурал семинарт 2-оос доошгүй удаа хамрагдсан байх, гэрчилгээний хуулбараар баталгаажуулна.
- Хэрэв эрдмийн зэрэг (АУ-ны магистр, доктор) хамгаалсан бол давуу тал болно.

